

БАТЛАВ
СУМЫН ЗАСАГ ДАРГА М.БАЯРСҮХ

БАТЛАВ
"ЭЛБЭГ САНЧИР" ХХК-НИЙ
ЗАХИРАЛ О.ХҮҮХЭНБААТАР

"СУМЫН ТӨВИЙН ГҮНИЙ ХУДАГ ГАРГАХ" АЖЛЫН ГЭРЭЭ

Дугаар № ДУГАДЦСЗДТГ/202101004

Дэлгэрцогт сум

Нэг талаас [Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын ЗДТГазар] (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас [Дундговь аймгийн Сайнцагаан сум, 7-р баг, Нарлаг 90 р байр "Элбэг санчир" ХХК ны захирал Оюунцэцэг овогтой Хүүхэнбаатар] (цаашид "гүйцэтгэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 06 дугаар сарын 05-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Захиалагч нь "Сумын төвийн гүний худаг гаргах" ДУГАДЦСЗДТГ/202101004 ажлыг (цаашид "ажил" гэх) 9.500.000 (есөн сая таван зуун мянга) (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв.

2. Гэрээний үнэ санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно. Санхүүжилтийг ажлын гүйцэтгэл болон урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн эхний ээлжид 50%, ажлаа комисст хүлээлгэн өгсний дараа 50% олгох ба ажлын 20 хоног дотор санхүүжилт хийнэ.

3. Гэрээний нийт дүн: 9.500.000 төгрөг. Үүнээс:

Барилга угсралтын ажил	8,316,900
НӨАТ	831,690
Нормчлолын сан	201,210
Захиалагчийн албаны зардал	150,200

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө: 2021 онд 9.500.000

4. Гүйцэтгэгч нь "Сумын төвийн гүний худаг гаргах" ажлыг 2021 оны 06 сарын 05 - ний өдөр эхэлж, 2021 оны 06 сарын 12 өдөр ашиглалтад оруулна.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг
Тендер;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт
Ажлын үе шатны ажлын хуваарь;
Ажлын зураг /Гүйцэтгэлийн зургаар/;
Санхүүжилтийн хуваарь;
Ажил гүйцэтгэх хуваарь

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
10. Засварын ажлыг батлагдсан зургийн дагуу гүйцэтгэх ба гэрээт хугацаандаа ашиглалтад өгөөгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,3 хувиар алданги ногдуулна. Гэхдээ алданги хүлээснээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөхгүй.
11. Захиалагч болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үл хамааран ажил гүйцэтгэх хугацаанд саатал гарсан тохиолдолд хамтран тохиролцож, ажлын графикт зохицуулалт хийсний үндсэн дээр ажил дуусгах хугацаанд өөрчлөлт оруулж болно.
12. Гүйцэтгэгч нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5, 6.9-т заасны дагуу мэдээллийг оруулах үүрэг хариуцлагыг хүлээнэ.
13. Тохижилтын ажил гүйцэтгэгч компани товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил,


үйлчилгээний баталгаат хугацааны туршид зааврыг заавал байрлуулах.
Байршуулаагүй тохиолдолд санхүүжилтийг олгохгүй.

Маргаан шийдвэрлэх

14. Энэхүү гэрээний холбоотой талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.
15. Хэрвээ санал зөрөлдөөнийг хэлэлцэн шийдвэрлэж чадахгүй бол хууль тогтоомжид заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
16. Энэхүү гэрээг 4 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗДТГ-ЫН ДАРГА  С. НАРАНТУНГАЛАГ
Утас: 94889922



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Элбэгсанчир" ХХКомпаний
нэгтгэн бодолч Н.Дагдорж

Хаяг: Сэйнцагаан сум, 7-р баг
Утас: 99193679
Хаан банк
Данс:
Регистрийн дугаар: 4246446



ГЭРЭЭ ДҮГНЭХ МАЯГТ


2021 он 05 сарын 12 өдөр

Гэрээний нэр:	Инженерийн хийцтэй худгийн цооног өрөмдөх, тоноглох ажил		
Гэрээний дугаар:	ДУГАДСЗДТГ/202101004		
Захиалагч байгууллага:	Сумын ЗДТГ		
Гүйцэтгэгч байгууллага:	"Элбэгсанчир" ХХК		
Гэрээгээр ажил эхлүүлэх хугацаа:	2021 оны 06 сарын 05		
Гэрээгээр ажил дуусгах хугацаа:	2021 оны 06 сарын 12		
Гэрээний дүн:	9.500.000		
Батлагдсан гүйцэтгэлийн дүн: 1.600.000	Санхүүжилтийн дүн: 9.500.000 төгрөг		
Үүнээс: БУА	8,316,900	Үүнээс олгогдсон:	
Захиалагчийн хяналт:	150,200		
Гомчлолын сан:	201,210		
НӨАТ	831690		
Чанарын баталгаат хугацаанд байршуулсан мөнгөн дүн (төгрөгөөр)	-0		
Гүйцэтгэгчээс ажил дууссан тухай мэдэгдэл ирүүлсэн өдөр:	2021 оны 6 сарын 11 өдөр Дугаар:		
Комиссын актын дугаар:	2021 оны 06 сарын 11 өдөр Дугаар:...		

Гэрээний биелэлт, шийдвэрлэлт:

Гэрээний биелэлт:	Ажил бүрэн дууссан. Комисс комиссын акт 2021 оны 06 сарын 11 -ны өдрийн дугаартай баталгаажсан.
Шийдвэр:	Иймд алданы тооцохгүйгээр 100 хувь 9.500.000 төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэв.

Гэрээ дүгнэсэн:

Сумын ЗДТГ-ын дарга  /С.Нарантунгалар/	ХИЙЦЭГЧ "Элбэгсанчир" ХХК-ний захирал:  /Ю.Хүүхэнбаатар/
Захиалагч талаас (дарга): Сумын Засаг даргын орлогч  /Л.Болжарал/	Захиалагч талаас (санхүү): Санхүү, төрийн сангийн албаны дарга  /Г.Уугантуяа/